

2008.02.28

Дугаар 26

“Бодь даатгал” ХХК-д ердийн даатгалын зарим  
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3,  
Даатгалын тухай хуулийн 20.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн  
зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

Нэг. “Бодь даатгал” ХХК-д даатгалын дараах хэлбэрүүдээр ердийн  
даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай. Үүнд:

1. Таримлын (1.2.12);
2. Баримт бичгийн (1.2.14);
3. Илгээмж шуудангийн (1.2.15);
4. Иргэдийн хариуцлагын (1.3.3);
5. Өмчлөгч болон эзэмшигчийн хариуцлагын (1.3.8);
6. Гэрээний хариуцлагын (1.3.12);
7. Зээлийн эрсдлийн (1.4.2);
8. Бэлэн мөнгөний (1.4.4).

Хоёр.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж  
ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, “Бодь даатгал” ХХК-ийн ердийн  
даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ  
тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрүүдийг нэмж бүртгэхийг Тамгын  
газар /Ж.Жадамбаа/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ